



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 49

Ховд

Тэргүүлэгчдийн хуралдааны дэг
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Тэргүүлэгчдийн хуралдааны дэг”-ийг хавсралтаар баталсугай.
2. Хуралдааны дэгийг мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 80

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Хөдөө аж ахуйн гавъяат ажилтан цол”-оор

1. Намсрай Булгаа - “Арван улиас” Хоршооны захирал

“Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-гоор

1. Далхаа Арвайхээр - Буянт сумын Нарийн гол багийн ахмад настан

“Алтан гадас одон”-гоор

1. Зоноров Цэдэнбямба - Алтай сумын Тахилт багийн малчин
2. Түвдэн Майдаржав - Эрдэнэбүрэн сумын “Топ үелзүүр” Хоршооны захирал
3. Дүнгэнбай Сарсанбай - Хөгжил Политехник коллежийн жижүүр
4. Ногойбай Ижан - Буянт сумын Норжинхайрхан багийн малчин
5. Амартайван Тошоо - “Ховд Мөнх түшиг” ХХК-ны барилгын засал чимэглэлчин

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар

- | | |
|----------------------|--|
| 1. Цогбадрах Цэнгэл | - “Ховд Мөнх түшиг” ХХК-ний бригадын
дарга |
| 2. Көпөй Алпысбай | - “Гурвалжин Холбоо” Хоршооны харуул
хамгаалалтын албаны хамгаалагч |
| 3. Аюушжав Банзрагч | - Дөргөний усан цахилгаан станцын
жолооч |
| 4. Доржсүрэн Нэмэх | - Буянт сумын Нарийн гол багийн малчин |
| 5. Жалав Бат-Очир | - Дөргөн сумын Сээр багийн малчин |
| 6. Янжив Өлгийсайхан | - Эрдэнэбүрэн сумын Баянгол багийн
малчин |

ХУРЛЫН ДАРГА



Г. ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 81

Ховд

Комисс байгуулах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын ажил хүлээлцэх комиссыг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: Г.Пүрэвганди –Аймгийн ИТХ-ын дарга
Гишүүд: Б.Амгаланбадрах – Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч
Л.Цэнд-Аюуш- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч
Ч.Чинбат- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч, Засаг даргын орлогч
Б.Батмөнх- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

2. Аймгийн Засаг даргын ажлыг 2016 оны 07 дугаар сарын 28-ны өдөр хүлээлцүүлэхийг комисс /Г.Пүрэвганди/-т даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 82

Ховд

Аймгийн Сонгуулийн хороо
байгуулах тухай

Монгол улсын Сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6, 31.11, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.5 дахь заалтуудыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг сонгох сонгуулийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах аймгийн Сонгуулийн хороог байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн Сонгуулийн хороог ажиллах нөхцөл боломж, байраар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгасугай.

3. Аймгийн Сонгуулийн хороо байгуулсан тухай нийтэд мэдээлэн, сурталчилж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Н.Бөхболд/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2016 оны 2-р дугаар
тогтоолын хавсралт

АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

№	Нэр, эцэг /эх/-ийн нэр	Нас, хүйс	Эрхэлж буй ажил, албан тушаал	Мэргэжил, боловсрол	Сонгуулийн хороонд эрхлэх ажил	Утасны дугаар	И-Мэйл хаяг
1.	Лхамсүрэнгийн Батбаяр	53 эр	Аймгийн Сум дундын Ой ангийн дарга	Багш, дээд	Сонгуулийн хорооны дарга	99432145	L.kham.Batbayar@yahoo.com
2.	Норовын Бөхболд	55 эр	Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга	Багш, дээд	Нарийн бичгийн дарга	99431207	lth_hovd@yahoo.com
3.	Аварзадын Оюунчимэг	55 эм	БГХӨТГ-ын дарга	Биологич, физиологич	Гишүүн	99432168	oyul_a@yahoo.com
4.	Дарьсүрэнгийн Чинбат	49 эр	Хар-Ус нуур орчмын УТХГН-ын хамгаалалтын захиргааны дарга	Агрономич, дээд	Гишүүн	99029815	
5.	Дамдинжавын Даваасамбуу	56 эр	Улсын бүртгэл, статистикийн газрын хэлтсийн дарга	Эдийн засагч, дээд	Гишүүн	99273610	hovd@nso.mn
6.	Баатаржавын Баярсүх	32 эр	МХГ-ын Захиргааны удирдлагын хэлтсийн дарга	Багш, дээд	Гишүүн	99438863	bayarsukh.b@yahoo.com
7.	Даваажавын Болормаа	41 эм	Жаргалант сумын 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч	Багш, дээд	Гишүүн	99021602	D.bolormaa75@yahoo.com
8.	Хумдаагийн Отгонбаяр	44 эм	Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн	Инженер, дээд	Гишүүн	99049668	oono_h2000@yahoo.com
9.	Уртнасангийн Цэрэнтогтох	34 эр	Аймгийн Засаг даргын Тамгын газрын НХХ-ийн мэргэжилтэн	Багш, дээд	Гишүүн	99433999	U.tserentogtoh@yahoo.com



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 83

Ховд

Санал дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 67 дугаар тогтоолын 67.1, 67.3 дахь заалтыг үндэслэн, аймгийн Засаг даргын 2016 оны 1/1258 тоот албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг хэлэлцээд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын Эдийн засаг, хөгжлийн бодлого хариуцсан орлогчоор Шагдарын Батсүхийг, Нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогчоор Чойсүрэнгийн Уранчимэгийг томилуулахаар ирүүлсэн саналыг дэмжсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 08 сарын 10 өдөр

Дугаар 84


Ховд

Дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.3, 67 дугаар зүйлийн 67.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн, аймгийн Засаг даргын саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн болон орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны төсөв, хөрөнгө оруулалтын 2017 оны төсвийн төсөл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн саналыг дэмжсүгэй.

2. Төсвийн төсөл, төсөөллийг боловсруулах болон хэлэлцэх явцад гарсан саналыг тусган холбогдох яамдад өргөн мэдүүлж, улсын нэгдсэн төсөвт тусгуулах арга хэмжээ авахыг аймгийн Засаг дарга /Д.Галсандондог/-д даалгасугай.



ХУРЛЫН ДАРГА

Г. ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 08 сарын 10 өдөр

Дугаар 86

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Монгол улсын Гавъяат барилгачин цол”-оор

1. Даржаа Пүрэвдорж - “Ховдын Тулга” ХХК-ний ахмад ажилтан
2. Дамба Бадамсүрэн - Буянтын Боргио ХХК-ний засал чимэглэлийн сургагч багш
3. Дүүдээ Намжил - Оюу Мандал ХХК-ний зөвлөх инженер
4. Намсрай Жанлав - Жаргалант сумын ахмад барилгачин

Монгол улсын “Гавъяат нисгэгч цол”-оор

1. Лувсан-Очир Батнасан - Ховд аймаг дахь Нисэх буудлын ахмад нисгэгч

“Монгол улсын “Гавъяат малчин цол”-оор

1. Түвшинжаргал Цогтоо - “Мянгад сумын Чацарганат багийн малчин

Монгол улсын “Байгаль орчны гавъяат ажилтан цол”-оор

1. Содов Бааст - “Хөх тохой сервис” ХХК-ний захирал

“Монгол улсын Соёлын гавъяат зүтгэлтэн” цолоор

1. Лэгзэн Мигжин - “Амгаланг үүсгэгч” Майдарын гэгээний хийдийн тэргүүн

“Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-гоор

1. Мажин Даваадай - Бичигт багийн өндөр настан
2. Самдан Агчинсүрэн - Чандмань сумын өндөр настан
3. Зул Самбалхүндэв - Жаргалант сумын өндөр настан
4. Бэгз Цэвээндорж - Ховд дахь Хөгжил Политехник коллежийн багш
5. Дүгэржав Бямбасүрэн - Ховд барилга Трестийн ахмад ажилчин
6. Жунтаан Бадамраа - Булган сумын өндөр настан

“Алтан гадас одон”-гоор

1. Ядамцоо Балсан - “Ховдын Тулга ХХК”-ын Механикч,
2. Сэрчин Долгорсүрэн - Жаргалант сум Бугат багийн өндөр настан
3. Өнөр Аримнаасүрэн - Жаргалант сум Бугат багийн өндөр настан
4. Юнгэрэндорж Доржсүрэн - Жаргалант сум Баатархайрхан багийн өндөр настан
5. Соном Түмэнжаргал - Жаргалант сумын 6 дугаар сургуулийн зөвлөх багш
6. Аваргаан Дуламсүрэн - Буянт сумын иргэн
7. Жанцан Дуламсүрэн - Жаргалант сум Баатархайрхан багийн өндөр настан
8. Дэлэг Нямаа - Жаргалант сум Магсаржав багийн өндөр настан
9. Мижид Нямдаваа - “Алтайн Буйлааст” ХХК, “Буянтын боргио” ХХК-ний барилгачин өрлөгчин
10. Цанжид Батцэнд - Ховд аймгийн Мянгад сумын иргэн
11. Ядамсүрэн Сандуй - Ховд аймгийн Мянгад сумын өндөр настан
12. Шотай Нуриман - Ховд сумын өндөр настан
13. Содов Балсан - Жаргалант сум Баатархайрхан багийн өндөр настан
14. Цагаан Гиймаа - Жаргалант сумын Цамбагарав багийн өндөр настан

“Цэргийн гавъяаны одон”-гоор

1. Сүхбаатар Эрдэнэбаатар - Жаргалант сумын Магсаржав багийн Засаг дарга

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар

1. Хяргис Буянхүү - Жаргалант сумын Тахилт багийн өндөр настан
2. Хорлоо Янжмаа - Жаргалант сумын Бугат багийн өндөр настан
3. Түдэвдорж Данаа - Жаргалант сум, Бугат багийн өндөр настан
4. Даш Цэрэнпил - Жаргалант сумын Жаргалан багийн өндөр настан
5. Намнан Долгор - Жаргалант сумын ахмад барилгачин
6. Самдан Цагаанцоож - БОЭТ-ийн эх баригч, нярайн сувилагч
7. Дамдин Хандсүрэн - Жаргалант сум, Ахмад барилгачин
8. Норов Балсан - Жаргалант сум, Ахмад Геодезчин
9. Мөнхөө Дарьсүрэн - Жаргалант сум, Баатархайрхан багийн иргэн
10. Чүлтэм Түвшинбаяр - Булган сумын өндөр настан
11. Цэнд Дэвээ - Дөргөн сумын өндөр настан
12. Дүгэрсүрэн Намсрайжав - Мянгад сумын иргэн
13. Жигжид Бат-Очир - Мянгад сумын иргэн

ХУРЛЫН ДАРГА



Г. ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 08 сарын 10 өдөр

Дугаар 84

Ховд

Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр
шагнах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны “Аймгийн шагналын журам батлах тухай” 131 дүгээр тогтоолын 1.3.4, 4.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд болон эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж буй дараах нэр бүхий иргэдийг Ховд аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнасугай. Үүнд:

- | | |
|------------------|--|
| 1. Ш. Нуриман | - Ховд сумын ЭМТ-ийн ахмад ажилчин |
| 2. Н. Халамия | - Ховд сумын ЭМТ-ийн ахмад ажилчин |
| 3. Ш.Гүлзада | - Ховд сумын ЭМТ-ийн ахмад ажилчин |
| 4. Н.Бэрхбол | -Ховд сумын ЭМТ-ийн эрхлэгч |
| 5. н.Жахсыхан | -Ховд сумын өндөр настан |
| 6. Н.Доржсүрэн | -Булган сумын 1 дүгээр сургуулийн сантехникч |
| 7. Г.Лхагвасүрэн | - Булган сумын 1 дүгээр сургуулийн жижүүр |
| 8. Г.Баттулга | - Булган сумын 1 дүгээр сургуулийн
үйлчилгээний ажилтан |
| 9. Л.Эрдэнэ-Очир | - Булган сумын 1 дүгээр сургуулийн
үйлчилгээний ажилтан |

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 08 сарын 11 өдөр

Дугаар 88

Ховд

Тогтоолд өөрчлөлт оруулах
тухай

Монгол улсын Сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 27 дугаар зүйлийн 27.4, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.5 дахь заалтуудыг үндэслэн, аймгийн Сонгуулийн хорооны саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Сонгуулийн хорооны бүрэлдэхүүнийг баталсан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 82 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулсугай.

2. Аймгийн Сонгуулийн хорооны нарийн бичгийн даргаар Д.Чинбатыг, гишүүнээр Н.Бөхболдыг тус тус томилсугай.



ХУРЛЫН ДАРГА *Г.Пүрэвганди* Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 08 сарын 17 өдөр

Дугаар 89

Ховд

Ажил эрчимжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.3, 22 дугаар зүйлийн 22.1.9 дэх заалтуудыг үндэслэн аймгийн хэмжээнд бүх шатны төрийн байгууллагуудын ажил үйлчилгээ, сахилга дэг журмыг бэхжүүлж, иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг тогтмолжуулан эрчимжүүлэх зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Засаг дарга /Д.Галсандондог/, сумдын Засаг дарга нарт ҮҮРЭГ БОЛГОХ нь:

1.1. Төрийн үйлчилгээний тасралтгүй, шуурхай байдлыг ханган, ажил хариуцсан албан тушаалтнуудын хариуцлага сахилгыг дээшлүүлэх;

1.2. Аймаг, сумын төсвийн орлогын бүрдүүлэлтэнд анхаарч, төсвийн зарлага, санхүүжилтийг хэмнэлтийн горимд шилжүүлж, иргэдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтыг бүрэн санхүүжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;

1.3. Төв суурин газрын цахилгаан хангамж, нэгдсэн халаалтын систем, усан хангамж, татуурга, албан байгууллагуудын халаалтын зуухны засвар үйлчилгээг жигдрүүлэн дуусгах, замын засвар, хадлан тэжээл бэлтгэх, нөөцлөлт, албан байгууллага, айл өрхийн өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангах ажлыг эрчимжүүлж, биелэлтийг шалган хүлээн авч, үнэлж дүгнэх;

1.4. Хичээлийн жил эхлэхээс өмнө сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжуудад хийгдэж байгаа засвар үйлчилгээг чанартай дуусган, боловсон хүчний хангамжийг бүрэн шийдвэрлэж, сургалтын бэлтгэл ажлыг хангах;

1.5. Эрүүл мэндийн салбарын ажил үйлчилгээний хүртээмжийг сайжруулан, халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, оношлогоо, эмчилгээний ажлын шуурхай зохион байгуулалтыг хангах;

1.6. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах, сум, байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, иргэний нийгмийн болон төсөл хөтөлбөр, олон улсын байгууллага, төлөөлөгчид, намын бүлгүүд, нутгийн зөвлөл, эрдэмтэд, судлаачдын аймаг орон нутгаа хөгжүүлэх хөгжлийн асуудлаар гаргасан саналыг нэгтгэх ажлыг шуурхай зохион байгуулах;

1.7. Иргэдийн ая тухтай ажиллаж, амьдрах нөхцлийг хангах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэхэд хууль хяналтын болон төрийн байгууллагуудын ажил үүргийг уялдуулан зохицуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

1.8. Байгууллагын 2016 онд дэвшүүлсэн зорилтоо бүрэн хэрэгжүүлээгүй, төрийн ажил, үйлчилгээний стандартыг алдагдуулж үйлчлүүлэгч иргэдэд хүндрэл учруулсан, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангаагүй албан тушаалтнуудад зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх;


1.9. Сумын ИТХ-ыг сонгох орон нутгийн сонгуулийг зохион байгуулахад бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх.

Хоёр. Сумын харьяа байгууллагуудын 2016 онд дэвшүүлсэн зорилтыг хангах, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулан, хэвийн тогтвортой ажиллуулах талаар тодорхой арга хэмжээ авч, биелэлтэнд хяналт тавьж, хариуцлага сахилгыг дээшлүүлж ажиллахыг сумдын ИТХ-ын дарга нарт зөвлөсүгэй.

Гурав. Тус тогтоолын хэрэгжилтийг хангаж, дүнг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны дотор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Д.Галсандондог/-д үүрэг болгосугай.

Дөрөв. Аймгийн хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Н.Бөхболд/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 08 сарын 17 өдөр

Дугаар 90

Ховд

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ийн “в”, 22 дугаар зүйлийн 22.1.10, аймгийн ИТХ-ын 2014 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Ховд Хөшөөт хөгжил сан”-гийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд дараахь өөрчлөлтийг оруулсугай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга: -Г.Пүрэвганди /Аймгийн ИТХ-ын дарга/
Гишүүдэд: -Ш.Батсүх /Аймгийн Засаг даргын орлогч/
-Ж.Гөлгөө /МоЭнКо ХХК-ны Засгийн газар, төр олон нийттэй харилцах асуудал эрхэлсэн захирал/
-Х.Болдбаатар /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч/
-Ю.Азамат /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч/

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн “Төлөөлөн удирдах зөвлөл байгуулах тухай” 2014 оны 68 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Сангийн үйл ажиллагааг удирдлагаар хангаж, хөрөнгө оруулалт, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын дарга, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Г.Пүрэвгандид үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 91

Ховд

Хорооны чиг үүрэг, бүрэлдэхүүнийг
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь заалт, аймгийн ИТХ-ын анхдугаар хуралдааны 1/47 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороодын чиг үүргийг 1 дүгээр хавсралтаар, бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Хорооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахыг хорооны бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 03

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:


“Алтан гадас одон”-гоор

- | | |
|----------------------|---|
| 1. Дэлэг Энхбаяр | - “Буянтын Боргио ХХК”- ний захирал |
| 2. Дорж Энхтүвшин | - 12 жилийн 3 дугаар сургуулийн сургалтын менежер |
| 3. Дашзэвэг Баярболд | - ХИС-ийн биеийн тамирын багш |

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар

- | | |
|--------------------------|---|
| 1. Цэвэгдорж Оюун-Эрдэнэ | - “Цагаан бөлбөө” ХХК-ний засал чимэглэлчин |
| 2. Бариаз Лхагважав | - “Цагаан бөлбөө” ХХК-ний засал чимэглэлчин |
| 3. Батдорж Энхболд | - “Ховдын Тулга” ХХК - ний цахилгааны инженер |
| 4. Авид Заяа | - “Ховдын Тулга” ХХК-ний бригадын дарга |
| 5. Магсар Алтанцэцэг | - “Ховдын Тулга” ХХК -ний арматурчин |
| 6. Гүнд Даваажав | - “Ланз” ХХК-ний засал чимэглэлчин |
| 7. Гомбожав Ган-Очир | - “Ланз” ХХК-ний мужаан |
| 8. Аюуш Ганболд | - Хөшөөтийн уурхайн жолооч |

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 94

Ховд

Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр
шагнах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны “Аймгийн шагналын журам батлах тухай” 131 дүгээр тогтоолын 1.3.4, 4.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд болон эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж буй дараах нэр бүхий иргэдийг Ховд аймгийн олон улсын нисэх буудал үүсэн байгуулагдсаны 60 жилийн ойг тохиолдуулан Ховд аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнасугай. Үүнд:

- | | |
|--------------------|--|
| 1. Х. Бат-Очир | - Ховд Нисэх буудлын ахмад ажилтан |
| 2. П.Болдбаатар | - Ховд Нисэх буудлын ахмад ажилтан |
| 3. З.Нарандэлгэр | - Ховд Нисэх буудлын ажмхд ажилтан |
| 4. Х.Отгонбаатар | - Ховд Нисэх буудлын дарга |
| 5. Л.Төмөрхуяг | - Дулааны “Бадамлах Дөл” ХХК-д ашиглалтын инженер |
| 6. В.Бадамцэцэг | - Дулааны “Бадамлах Дөл” ХХК-д лаборант |
| 7. М.Бузовай | - Дулааны “Бадамлах Дөл” ХХК-д засварын механик |
| 8. Ш.Хажигал | - Дулааны “Бадамлах Дөл” ХХК-д шугам сүлжээний слесарь |
| 9. Ч. Лувсанпүрэв | - Дулааны “Бадамлах Дөл” ХХК-д шугам сүлжээний слесарь |
| 10. Д.Ганболд | - Дулааны “Бадамлах Дөл” ХХК-д шугам сүлжээний слесарь |
| 11. С.Баасанжаргал | - Дулааны “Бадамлах Дөл” ХХК-д шугам сүлжээний слесарь |
| 12. Н.Батчимэг | - Жаргалант сумын Бичигт багийн иргэн |

- | | |
|-----------------------------|---|
| 13. Г.Баярхүү | - БОЭТ-ийн халдвартын тасгийн үйлчлэгч |
| 14. А.Мария | - БОЭТ-ийн шинжилгээний тасгийн үйлчлэгч |
| 15. Х.Аюурзана | - Аймгийн Цагдаагийн газрын ахмад ажилтан |
| 16. Д.Бямбасүрэн | - Аймгийн Цагдаагийн газрын сэтгэл зүйч |
| 17. Ц.Равданпүрэв | - Аймгийн Цагдаагийн газрын аж ахуйн офицер |
| 18. С.Жанбаатар | - Аймгийн Цагдаагийн газрын хэв журмын тасгийн ахлах байцаагч |
| 19. Заяанамрал Насанбат | - Дарви сумын Цагдаагийн газрын хэсгийн төлөөлөгч |
| 20. Ж.Алтанцэцэг | - Жаргалант сумын Тахил багийн ахмад настан |
| 21. Г. Даваа | - Ус цаг уурын хүрээлэнгийн ус судлалын секторын эрхлэгч |
| 22. Х. Пүрэвдагва | - Ус цаг уурын хүрээлэнгийн технологийн инженер |
| 23. Б.Цэвээн | - Жаргалант сумын Тахилт багийн ахмад настан |
| 24. Ц.Өлзийбат | - Жаргалант сумын Бугат багийн иргэн |
| 25. Г.Ган-Очир | - "Ланз" ХХК-ний мужаан |
| 26. Ц.Алтанхуяг | - "Жаргалант луу" ХХК-ний жолооч |
| 27. Х.Оюунбат | - "Жаргалант луу" ХХК-ний барилгын инженер |
| 28. А.Дуламсүрэн | - "Жаргалант луу" ХХК-ний засал чимэглэлчин |
| 29. Ш.Пүрэвдорж | - "Жаргалант луу" ХХК-ний гагнуурчин |
| 30. Д.Соронзонболд | - "Жаргалант луу" ХХК-ний сантехникч |
| 31. З.Оюун | - Ховд "Мөнх түшиг" ХХК-ний бетон арматурчин |
| 32. Баруш Давааням | - Ховдын "Хаш өргөө" ХХК-ний бригадын дарга |
| 33. Пагамжав Буяндэлгэр | - "Ховдын өргөө" ХХК-ний тооцооны ня-бо |
| 34. Гомбожав Цэрэнханд | - "Вестерн Холд" ХХК-ний ерөнхий ня-бо |
| 35. Норжинчулуун Өлзийхутаг | - Аймгийн Цагдаагийн газрын дэд дарга |
| 36. Найдан Батмөнх | - Барилга угсралтын трестийн ахмад ажилтан |

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 95

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Алтан гадас одон”-гоор

1. Бадарч Барсболд - ХИС-ийн биеийн тамирын багш

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар

1. Сэрээтэр Баасанхүү - “Буянтын боргио” ХХК-ний захирал
2. Мижид Нямдаваа - “Буянтын боргио” ХХК-ний өрөгч, мужаан
3. Сэнгэдорж Пүрэв-Очир - “Буянтын боргио” ХХК-ний цахилгааны мастер

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 96

Ховд

Орон нутгийн өмчийн 2015 оны
тооллогын дүнгийн тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-ийн 20.1.2, 20.1.14, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-ийн 2 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 439 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн орон нутгийн өмчийн тооллогыг зохион байгуулах аймгийн комиссоос танилцуулсан аймгийн 2015 оны орон нутгийн өмчийн тооллогын дүнг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн өмчийн байгууллагуудын 2015 оны жилийн эцсийн дүнгээр өмчийн тооллогод хамрагдсан хуулийн этгээдийн мэдээлэлийг 1 дүгээр хавсралтаар, газрын бүртгэлийг 2 дугаар хавсралтаар, барилга байгууламжийн нэгтгэлийг 3 дугаар хавсралтаар, нийтийн эзэмшлийн байгууламжуудын нэгтгэлийг 4 дүгээр хавсралтаар, дуусаагүй барилга, байгууламжийн нэгтгэлийг 5 дугаар хавсралтаар, тээврийн хэрэгсэлийн нэгтгэлийг 6 дугаар хавсралтаар, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн нэгтгэлийг 7 дугаар хавсралтаар, мал амьтадын бүртгэлийг 8 дугаар хавсралтаар, худаг услалтын системийн нэгтгэлийг 9 дүгээр хавсралтаар, оюуны өмчийн нэгтгэлийг 10 дугаар хавсралтаар, түүх соёлын дурсгалт зүйлийн нэгтгэлийг 11 дүгээр хавсралтаар, бүртгэлд тусгагдаагүй үндсэн хөрөнгийн нэгтгэлийг 12 дугаар хавсралтаар, дутагдуулсан үндсэн хөрөнгийн бүртгэлийг 13 дугаар хавсралтаар, маргаантай үндсэн хөрөнгийн нэгтгэлийг 14 дүгээр хавсралтаар, илүүдэлтэй, ашиглагдаагүй үндсэн хөрөнгийн нэгтгэлийг 15 дугаар хавсралтаар, улсын болон орон нутгийн чанартай авто замын нэгтгэлийг 16 дугаар хавсралтаар, улсын болон орон нутгийн чанартай гүүрийн нэгтгэлийг 17 дугаар хавсралтаар, түрээслүүлсэн үндсэн хөрөнгийн нэгтгэлийг 18

дугаар хавсралтаар, барилга байгууламж түрээслэн ашигладаг байгууллагын судалгааг 19 дүгээр хавсралтаар, орон нутгийн өмчийн байгууллагуудын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийг 20 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн ИТХ-ын дарга /Г.Пүрэвганди/-д ДААЛГАХ нь:

2.1.Хурлын байгууллагын өмчлөгчийн эрхийг бүрэн хэрэгжүүлэхээр байгууллагуудад эзэмшүүлэн ашиглуулж буй орон нутгийн өмчийг олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэхэд тавих хяналтыг сайжруулж өмчийн ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах;

2.2.Орон нутгийн өмчийн байгууллагуудын данс бүртгэлд байгаа илүүдэлтэй болон ашиглалтын зардал өндөртэй, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй болсон хөрөнгийг зохих журмын дагуу Төрийн өмчийн хороонд танилцуулан саналыг авч хувьчлах, худалдах асуудлыг 2017 онд багтаан шийдвэрлэх.

3. Аймгийн Засаг дарга /Д.Галсандондог/-т ҮҮРЭГ БОЛГОХ нь:

3.1.Орон нутгийн өмчийн тооллогын явцад хөрөнгийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт, ашиглалт, мэдээлэл тайлагналт, газрын бүртгэлийн талаар илэрсэн зөрчил дутагдлыг 2016 онд багтаан бүрэн арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэн, буруутай албан тушаалтанд зохих хариуцлага тооцох;

3.2.Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлэн бүртгүүлээгүй, эзэмшиж буй газрын эрхийн гэрчилгээ аваагүй, авсан гэрчилгээ нь улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлээгүй зэрэг зөрчил илэрсэн байгууллагуудын зөрчлийг 2016 оны 12 дугаар сард багтаан бүрэн арилгах;

3.3.Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бүх шатны төсөв захирагчдаас үндсэн хөрөнгө олж бэлтгэх, данснаас хасах асуудлыг таслан зогсоож хөрөнгийн ашиглалтын үр ашгийг сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх;

3.4.Орон нутгийн өмчийн байгууллагуудын өмч эзэмшүүлэх гэрээг 2017 оны 1 дүгээр улиралд багтаан шинэчлэн байгуулж жил бүр дүгнэж хөрөнгийн ашиглалтын үр дүнг тооцож ажиллах;

3.5.Орон нутгийн өмчлөлд байгаа илүүдэлтэй байгаа болон ашиглалтын хугацаа дууссан, зардал өндөртэй хөрөнгийн судалгааг нарийвчлан гаргаж цаашдын ашиглалтын асуудлыг 2017 оны эхний хагас жилд багтаан эрх бүхий байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх;

3.6.Байгууллагуудын өмч хөрөнгийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт, ашиглалт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлагналт, складын тохижилт, ашиглалтыг сайжруулан холбогдох хууль тогтоомж, заавар, журам, стандартын хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтэнд хяналт тавьж ажиллах;

3.7.Өмч хөрөнгийн бүртгэл хөтлөлт, хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг хариуцан ажиллаж буй төсвийн захирагч, нягтлан бодогч, нярав, өмч хамгаалах зөвлөлийн хоорондын ажлын уялдаа, холбоог оновчтой зохион байгуулж хөрөнгийн ашиглалтын үр дүнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

3.8.Орон нутгийн өмчийн байгууллагуудын өмчийн тооллогын дүнг тогтоосон хугацаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэн тайлагнах;

4. Тус тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Сандагсүрэн/- д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 97

Ховд

Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр
шагнах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны “Аймгийн шагналын журам батлах тухай” 131 дүгээр тогтоолын 1.3.4, 4.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд болон эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж буй дараах нэр бүхий иргэдийг Ховд аймгийн олон улсын нисэх буудал үүсэн байгуулагдсаны 60 жилийн ойг тохиолдуулан Ховд аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнасугай. Үүнд:

- | | |
|-------------------------|---|
| 1. Мянгаджав Амарбаяр | - Хилийн 0130 дугаар ангийн шифрийн ахлах
ажилтан |
| 2. Эрдэнэбаяр Баттогтох | - Хилийн 0130 дугаар ангийн хилийн 1дүгээр
заставт жагсаалын дарга |
| 3. Туниг Цэрэнноров | - Хилийн 0130 дугаар ангийн хүнсний албаны тогооч |
| 4. Даваа Гөлгөө | - Эрдэнэбүрэн сумын Цэцэрлэгийн ахмад ажилтан |
| 5. Пэрэнлэй Галхүү | - Эрдэнэбүрэн сумын Цэцэрлэгийн ахмад ажилтан |
| 6. Луузан Гиймаа | - Эрдэнэбүрэн сумын Цэцэрлэгийн ахмад ажилтан |
| 7. Балдан Гантөмөр | - Эрдэнэбүрэн сумын Цэцэрлэгийн тогооч |
| 8. Цэндбаяр Оюунчимэг | - Эрдэнэбүрэн сумын Цэцэрлэгийн ахмад ажилтан |
| 9. Нохойжав Сарантуяа | - Буянт сумын 12 жилийн сургуулийн багш |
| 10. Самбуу Загдсүрэн | - Буянт сумын 12 жилийн сургуулийн ахмад ажилтан |
| 11. Сандуйжав Нямхүү | - Буянт үйлийн шим хоршоонд оёдолчин |

12. Чойжинжав Нямжав - Буянт үйлийн шим хоршоонд оёдолчин
13. Цэдэнбал Ган-Очир - Жаргалант сумын 7 дугаар сургуулийн физикийн багш
14. Галсанням Оюунчимэг - Жаргалант сумын 7 дугаар сургуулийн үйлчлэгч
15. Цэрэн Довдонбазар - Жаргалант сумын 8 дугаар цэцэрлэгт галч
16. Алтангэрэл Отгонцэцэг - Мөст сумын Төрийн банкны теллер

ХУРЛЫН ДАРГА  Г. ПҮРЭВГАНДИ

